



## СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2021 оны 01 сарын 25 өдөр

Дугаар A/21

Сүхбаатар сум

Төрийн архивын барилгын зураг,  
төсөв хийлгэх ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.4 "а", 29.1.6 "а", Төрийн албаны тухай хуулийн хуулийн 61.1.2, Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.1, 35.1.2, 35.1.3, Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.5.1, 5.5.2, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн "Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай" 13 дугаар тогтоолын 2, "Сэлэнгэ аймгийн 2021 оны хөгжлийн жилийн төлөвлөгөөг батлах тухай" 14 дүгээр тогтоолын 2 дахь хэсэг, Хууль, зүй дотоод хэргийн яамны 2020 оны 12 дугаар сарын 03-ны 3/1900 албан тоотыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 4.2.6 дахь зорилт, аймгийн 2021 оны хөгжлийн төлөвлөгөөний 7.4.10 дахь арга хэмжээний хэрэгжилтийг эхлүүлж, "Төрийн архив"-ын барилгын зураг, төсөв хийлгэх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай. Үүнд:

Ажлын хэсгийн ахлагч:

-Ө.Сувдаа

/Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга/

Нарийн бичгийн дарга

-Д.Ёндонжамц

/Аймгийн ЗДТГ-ын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга/

Гишүүд:

-Б.Болорзул

/Аймгийн ЗДТГ-ын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга/

-А.Эрдэнэгэрэл

/Аймгийн ЗДТГ-ын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга/

-Д.Лувсандагва

/Аймгийн ЗДТГ-ын Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтсийн дарга/

-О.Мөнхбаяр

/Аймгийн ЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга/

-Б.Оюун

/Аймгийн ЗДТГ-ын Нийгмийн бодлогын хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч/

- Б.Хишигням /Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн Архивын тасгийн дарга/
- Б.Саруултөгс /Аймгийн газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын дарга/
- Д.Баттүвшин /Аймгийн Мэргэжлийн хяналтын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч
- Б.Энхбаатар /Аймгийн Онцгой байдлын газрын дарга/
- Б.Мөнхбат /"Сэлэнгэ Барилга захиалагч" ОНӨААТҮГ-ын дарга/
- Б.Эрдэнэбаатар /"Сэлэнгэ Энерго" ОНӨААТҮГ-ын дарга/
- А.Алтансүх /Урсгал ус ХХК-ий захирал/
- Э.Сувдаа /Дархан-Сэлэнгийн цахилгаан түгээх сүлжээ ХХК захирал/

2.Төрийн архивын барилгын зураг, төсвийн саналыг бэлтгэж 2021 оны 02 дугаар сард багтаан танилцуулахыг ажлын хэсэгт даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ш.ОРГИЛ